

Дүрсийн талбай, периметр

1. Гурвалжны нэг тал 10 см, 2-р тал 2см урт, 3-р тал 2 см богино болно. Гурвалжны периметрийг олоорой.

18 см 20 см 14 см 30 см

2. Тэгш өнцөгтийн нэг тал нөгөө талаас 2 дахин их, харин түүний периметр 12 см байв. Тэгш өнцөгтийн бага талыг олоорой.

3см 4 см 2 см 6 см

3. Тэгш өнцөгтийн нэг тал 3м. Харин нөгөө нь 2м их байв. Тэгш өнцөгтийн талбайг олоорой.

6м.кв 15 м.кв 10м.кв 25 м.кв

4. Тус бүрийн талбай нь 1 см.кв байх ижилхэн 2 квадратыг эвлүүлж тэгш өнцөгт үүсгэв. Түүний периметрийг олоорой.

2 см 1 см 4 см 6 см

5. 3 см ба 6 см талуудтай тэгш өнцөгтийг 2 квадрат болгон хуваав. Энэ квадратуудын периметрийн нийлбэрийг олоорой.

18 см 24 см 9см 12 см

6. 6 см талтай квадратаас 2 см талтай 2 квадратыг таслан авав. Үлдсэн дүрсийн периметрийг ол.

24 см 20 см 16 см 12 см

7. Тэгш өнцөгтийн талбай 24 см.кв, харин түүний талууд нь натурал тоонууд болно. Уг тэгш өнцөгтийн периметр байж болох тоо аль нь вэ?

21 см 28 см 24 см 48 см

8. Тэгш өнцөгт нь периметрүүдийн нийлбэр 24 см байх гурван ижил квадратад хуваагджээ. Тэгш өнцөгтийн талбайг олно уу.

16 см.кв 18 см.кв 12 см.кв

9. Гурвалжны нэг тал 13 см, 2-р тал 3см урт, 3-р тал 3 см богино болно. Гурвалжны периметрийг олоорой.

26 см 19 см 39 см 33 см

10. Тэгш өнцөгтийн нэг тал нөгөө талаас 3 дахин их, харин түүний периметр 16 см байв. Тэгш өнцөгтийн их талыг олоорой.

2 см 3см 5 см 6см

11. Тэгш өнцөгтийн нэг тал 4м, харин нөгөө нь 3м их байв. Тэгш өнцөгтийн талбайг олоорой.

12 м.кв 28 м.кв 4м.кв 49 м.кв

12. Тус бүрийн талбай нь 4 м.кв байх ижилхэн 2 квадратыг эвлүүлж тэгш өнцөгт үүсгэв. Түүний периметрийг олоорой.

16м 12 м 32м 6м

13. 8 см ба 16 см талуудтай тэгш өнцөгтийг 2 квадрат болгон хуваав. Энэ квадратуудын периметрийн нийлбэрийг олоорой.

64 см 48 см 40 см 24 см

14. 8 см талтай квадратаас 2 см талтай 2 квадратыг таслан авав. Үлдсэн дүрсийн периметрийг ол.

28 см 24 см 30 см 32 см

15. Тэгш өнцөгтийн талбай 12 см.кв, харин түүний талууд нь натурал тоонууд болно. Уг тэгш өнцөгтийн периметр байж болох тоо аль нь вэ?

30 см 18 см 12 см 26 см

16. Тэгш өнцөгт нь периметрүүдийн нийлбэр 12 см байх гурван ижил квадратад хуваагджээ. Тэгш өнцөгтийн талбайг олно уу.

8 см.кв 6 см.кв 3 см.кв 12 см.кв